

Tridumkey





E-MONGOLIA.MN САЙТАД ТООН ГАРЫН ҮСГЭЭРЭЭ НЭВТРЭХ ЗААВАР

1. TRIDUMKEY CLIENT ПРОГРАМ СУУЛГАХ

1.1. TRIDUMKEY CLIENT


1. Тридумкей аппликейшнийг татахын тулд www.tridumkey.mn вэб хуудасны гарын авлага хэсгийн баруун доор байрлах апп татах хэсгийн **windows client** программыг татаж суулгана.




3. Yes дарж үргэлжлүүлнэ үү.




4. **Next** товч дарна уу.




5. **Typical** товч дарж үргэлжлүүлнэ үү.






6. **Next** товч дарж үргэлжлүүлнэ үү.



7. **Install** товч дарж суулгана уу.



8. Програмыг суулгаж дуусгахын тулд **Finish** дарна уу.

9. Та компьютерээ **Restart** хийх шаардлагатайг анхаарна уу.

Анхааруулга: Тоон гарын үсгийг бүртгүүлэх болон ашиглахын тулд TridumKey Client програм нь заавал ажиллаж байх ёстойг анхаарна уу!


1.2 ТОКЕН ТӨХӨӨРӨМЖИЙГ АЖИЛЛУУЛАХАД БЭЛДЭХ

Токен төхөөрөмжийг компьютерийнхаа USB портонд залгаснаар төхөөрөмжийг ашиглахад бэлэн болно.


E-MONGOLIA.MN САЙТАД ТООН ГАРЫН ҮСГЭЭРЭЭ ХЭРХЭН НЭВТРЭХ ВЭ?

Алхам 1

Дурын нэг интернэт хөтчөөс www.e-mongolia.mn сайт хандан нэвтрэх товчийг дарна.




Алхам 2. Байгууллага хэсгийг сонгож Тоон гарын үсэг авсан хүн өөрийн хувь хүний регистрийн дугаарыг оруулаад үргэлжлүүлэн токен төхөөрөмжөө ашиглахад бэлэн эсэхийг шалгана.




Алхам 3. Токен төхөөрөмжийг компьютерт залгана.



Та компьютерын дэлгэц дээрээсээ “Tridumkey Client” программын лого дээр 2 товшноор програм ачааллаж доорх зурагт харагдаж буй хэлбэрээр таскбарлуу шилждэг.




Таскбар хэсэг дэх “Tridumkey Client” программ дээр 2 товшноор программын ажиллах талбар томоор нээгдэнэ.



“Tridumkey Client” программын зурагт дугуйлсан “Гэрчилгээ харах” сонголт хийснээр таны тоон гарын үсгийн мэдээлэл гарч ирнэ . Энэхүү мэдээлэл дээрх овог нэрээ зөв эсэхийг шалгаад дараагийн алхмыг үргэлжлүүлээрэй.

Алхам 4

Алхам 2 дээрх талбарт тоон гарын үсэг эзэмшигчийн регистрийн дугаарыг оруулан “Нэвтрэх” товч дараад гарч ирэх токен төхөөрөмжийн гэрчилгээний жагсаалтаас хувь хүн эсвэл хуулийн этгээдийн нэрийг сонгоод ПИН КОД хэсэгт нууц үгийг оруулан “СОНГОХ” товч дарна.



Алхам 5.

ЗӨВШӨӨРӨХ товч дарснаар та Төрийн цахим системд нэвтэрнэ. Системд нэвтэрсний дараа шаардлагатай үйлчилгээгээ сонгон үйлчлүүлээрэй.

